



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 203

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.3 дахь заалт, Удирдах зөвлөлийн 2017 оны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Соёл, Урлагийн Их Сургуулийн албан хэрэгцээнд зориулан 100,000,000.00 (нэг зуун сая) төгрөгт багтаан өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр, хавсралтад заасан үндсэн хөрөнгө олж авахыг зөвшөөрч, худалдан авах хөрөнгийн үнийн дээд хязгаарыг хавсралтаар тогтоосугай.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэн, Соёл, Урлагийн Их Сургуулийн захирал Э.Сонинтогос нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001700

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 05 дүгээр сарын 13-ны өдрийн
203 дугаар тогтоолын хавсралт



Соёл, Урлагийн Их Сургуулийн олж авах
үндсэн хөрөнгө

Д/д	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Төсөвт өртөг буюу худалдан авах үнийн дээд хязгаар
				(төгрөг)
1	Сургуулийн дадлагын баазын боловсон ариун цэврийн байр барих ажил	ш	1	65,000,000.00
2	Автомашин , суудлын тоо 7-12, хөдөлгүүрийн багтаамж 3500 сс хүртэл	ш	1	35,000,000.00
Нийт дүн			1	100,000,000.00
				(нэг зуун сая)